

## Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх товчоо

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

- БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.
- 1962-8-19-нд Сайд нарын Зөвлөлийн 481-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх товчоог 1962-10-1-нээс 4 оронтойгоор байгуулахаар тогтоожээ.
- 1967-10-25-нд Сайд нарын Зөвлөлийн 325 дугаар тогтоолоор иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх, удирдах зохион байгуулах ажлыг орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд хариуцуулж, аймаг, хотын цагдан сэргийлэхийн иргэний гэр бүлийн байцаагчийн орон тоог хасчээ.
- Сайд нарын Зөвлөлийн 1976-6-10-нд 128 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтсийг 3 орон тоотой байгуулахаар тогтоожээ.
- 1978-9-11-нд Сайд нарын зөвлөлийн 294-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орон тоог 102 нэгжээр, зохион байгуулалтыг
  - а/ зохион зааварлах хэлтэс
  - б/ санхүүгийн хэлтэс
  - в/ төлөвлөгөөний комисс
  - г/ статистикийн товчоо
  - д/ ардын боловсролын хэлтэс
  - е/ хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс /гадаадынхарьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцах тасагтай/
  - ж/орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс
  - з/ цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс
  - и/ их барилгын хэлтэс
  - к/ иргэний гэрбүлийн байдлыг бүртгэх хэлтэс
  - л/ соёлын хэлтэс
  - м/ эрүүлийг хамгаалах газар
  - н/ хөдөө аж ахуйгудирдах газар
  - о/ аж ахуйн хэлтэстэйгээр баталжээ.